



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/493

Арвайхээр

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дүн, цаашид авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь заалт, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулах удирдамж"-ын 2.4, 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дүн, цаашид авах арга хэмжээ"-ний талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12 дугаар хурлаар хэлэлцээд улсын үзлэгт амжилттай дүн үзүүлсэн байгууллагуудыг нэгдүгээр хавсралтаар баталж холбогдох албан хаагчдад олгох урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс шийдвэрлэхийг төсвийн ерөнхийлөн болон төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

2. Үйл ажиллагааны үр дүн, улсын үзлэгийн үзүүлэлтээр амжилттай дүгнэгдсэн аймгийн Засаг даргын Тамгын газар, Баруунбаян-Улаан сумын Ерөнхий боловсролын сургууль, Арвайхээр сумын 2, 6 дугаар цэцэрлэг, Өлзийт сумын Цэцэрлэгийн дарга, захирал, эрхлэгч нарыг 1 сарын үндсэн цалингаар урамшуулахыг дээрх байгууллагуудын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Улсын үзлэгт амжилттай дүгнэгдсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Т.Гончигдорж, Мэргэжлийн хяналтын газрын дарга С.Дуламсүрэн, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Норгинбадам, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Б.Оюунчимэг, Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга Б.Батжаргал, Монголын цахилгаан холбоо ХК-ны Өвөрхангай аймаг дахь Холбооны газрын дарга Н.Ширчин нарт урамшуулал олгох саналыг холбогдох дээд шатны удирдлагад уламжлан шийдвэрлүүлэхийг Салбар комиссын дарга (Ц.Ганболд)-д даалгасугай.

4. Тус үзлэгийн дүнгээр хангалтгүй дүгнэгдсэн байгууллагуудыг хоёрдугаар хавсралтаар баталж, холбогдох албан хаагчдад хариуцлага тооцон, архив албан хэрэг хөтлөлтийн төлбөртэй сургалтад хамруулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг мэдээлж ажиллахыг тухайн байгууллагын дарга, Төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

011101511

2.

5. Байгууллагын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаагүй, хангалтгүй дүгнэгдсэн байгууллагуудын улсын үзлэгийн дүнг холбогдох дээд шатны удирдлагад уламжлан танилцуулж, удирдлагын ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах талаар санал хүргүүлэхийг Салбар комиссын дарга (Ц.Ганболд)-д даалгасугай.

6. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 20-ны өдрийн 1/193 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГ”-Т
АМЖИЛТТАЙ ДҮН ҮЗҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

| Д/д | Байгууллагын нэр |
|-----|---|
| 1. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 2. | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 3. | Мэргэжлийн хяналтын газар |
| 4. | Нийгмийн даатгалын хэлтэс |
| 5. | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв |
| 6. | Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 7. | Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газар |
| 8. | Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги |
| 9. | Баруунбаян-Улаан сумын Ерөнхий боловсролын сургууль |
| 10. | Өлзийт сумын Цэцэрлэг |
| 11. | Арвайхээр сумын 2 дугаар цэцэрлэг |
| 12. | Арвайхээр сумын 6 дугаар цэцэрлэг |
| 13. | МЦХ ХК-ны Өвөрхангай аймаг дахь Холбооны газар |

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 30-ны өдрийн 4796 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГ”-Т
ХАНГАЛТГҮЙ ДҮН ҮЗҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГ СААЛТ**

| Д/д | Байгууллагын нэр |
|-----|---|
| 1. | Бүрд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 2. | Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 3. | Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 4. | Онцгой байдлын газар |
| 5. | Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар |
| 6. | Тарагт сумын Туяа багийн Бага сургууль |
| 7. | Бүрд сумын Соёлын төв |
| 8. | Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК |
| 9. | ӨВ-АЗЗА ТӨХК |